



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/206

Алтай хот

**Гэрээ шууд байгуулах эрх  
шилжүүлэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Ээж хайрхан уулын отоглох цэгийг түшиглэн говийн унаган ургамал болох заг болон говийн бут сөөг тарималжуулах ажлыг 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгөөр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиглахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (С.Амгалан)-т тус тус даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/204 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР